ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2026/131/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Зуунмод 2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Сугармаа

Утас: 70273465 Цахим хаяг: sugarmaag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........................................................................ 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..................................... 4
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........................................................................................ 112

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| УБЦТС | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**ТӨВ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tov@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026. 02. 25 № 01/142

танай ______________ -ны № ______________ -т

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАНДИНЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалтай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар нь нийт 392,837.1 мянган төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлд тусгаснаас 109,529.9 мянган төгрөгийн өр төлбөрийг холбогдох байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, бараа материалын жилийн эцсийн тооллого хийсэн боловч илтгэх хуудсаар баримтжуулж, дүнг нэгтгээгүй зэрэг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Оны эцэст авлага дансны үлдэгдэл 40,499.0 мянган төгрөг болж өмнөх оноос 14,995.5 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх онд үүссэн хувь хүмүүсээс

41[illegible]6020310

авах 2,972.7 мянган төгрөгийн, байгууллагаас авах 12,022.8 мянган төгрөгийн авлага тус тус барагдсан. ХАА-н агрегат трактор нийлүүлэх ажлын 31,255.0 мянган төгрөг, Хэрлэн голын бярвааз засварлах ажлын 9,000.0 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 244.0 мянган төгрөг нийт 40,499.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнасан байна. ХАА-н агрегат трактор нийлүүлэх аж ахуйн нэгжид холбогдох авлагын асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 603,194.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар болон аймгийн төсвийн санхүүжилтээр хөрөнгө авч, данс бүртгэлд тусгасантай холбоотой байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 40 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 90,0 хувьтай дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 167,285,370.5 | 146,410,884.0 |
| 33 | АВЛАГА | 54,998,520.0 | 40,499,000.0 |
| 335 | Бусад авлага | 54,998,520.0 | 40,499,000.0 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 51,781,800.0 | 40,255,000.0 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 3,216,720.0 | 244,000.0 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 112,286,850.5 | 105,911,884.0 |
| 354 | Хангамжийн материал | 99,786,850.5 | 93,411,884.0 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,751,000.0 | 2,350,600.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 61,980,374.5 | 73,622,684.0 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 0.0 | 1,104,000.0 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,300,000.0 | 0.0 |
| 35460 | Хүнсний материал | 904,300.0 | 0.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 30,851,176.0 | 16,334,600.0 |
| 35600 | Мал амьтад | 12,500,000.0 | 12,500,000.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,034,324,670.6 | 4,637,518,806.0 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,034,324,670.6 | 4,637,518,806.0 |
| 392 | Биет хөрөнгө | 3,860,847,254.0 | 4,504,016,806.1 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,468,030,578.0 | 1,639,149,603.0 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -340,432,394.8 | -409,177,559.6 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 930,187,497.2 | 1,294,155,847.3 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -415,448,997.2 | -374,152,831.2 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 230,825,061.1 | 242,559,817.9 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -159,107,145.0 | -153,113,502.0 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 111,635,235.0 | 112,610,935.0 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -81,243,032.3 | -85,502,335.1 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 807,160,996.0 | 840,548,755.0 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -175,336,416.7 | -189,944,932.7 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,279,209,592.0 | 2,600,593,179.0 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -841,218,419.3 | -<br>1,065,294,870.5 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 43,035,600.0 | 48,035,600.0 |
| 39217 | Ном | 3,549,100.0 | 3,549,100.0 |
| 393 | Биет бус хөрөнгө | 173,477,416.7 | 133,501,999.9 |
| 39301 | Програм хангамж | 12,530,000.0 | 12,330,000.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -4,092,500.0 | -5,680,000.1 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 217,537,000.0 | 217,537,000.0 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -52,497,083.3 | -90,685,000.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,201,610,041.1** | **4,783,929,690.0** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 5,633,718.1 | 392,837,082.4 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 5,633,718.1 | 392,837,082.4 |
| 413 | Өглөг | 5,633,718.1 | 392,837,082.4 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,300,218.1 | 1,887,891.6 |
| 4136 | Бусад өглөг | 4,333,500.0 | 390,949,190.8 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 4,000,000.0 | 380,149,190.8 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 333,500.0 | 10,800,000.0 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,195,976,323.0 | 4,391,092,607.6 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,195,976,323.0 | 4,391,092,607.6 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 667,794,348.4 | 667,794,348.4 |
| 51101 | Өмч: - төрийн | 667,794,348.4 | 667,794,348.4 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 3,327,582,057.0 | 3,523,566,316.6 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,327,582,057.0 | 3,328,450,032.0 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 195,116,284.6 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 200,599,917.6 | 199,731,942.7 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,201,610,041.1** | **4,783,929,690.0** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,036,528,743.8** | **2,083,990,983.4** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 490,497,536.3 | 478,123,336.6 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 490,497,536.3 | 478,123,336.6 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 490,497,536.3 | 0.0 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 490,497,536.3 | 478,123,336.6 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/ | 0.0 | 436,877,337.1 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан /бараа материал | 0.0 | 41,245,999.5 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,546,031,207.5 | 1,605,867,646.8 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 185,483,907.5 | 298,496,377.7 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,000,000.0 | 0.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 95,207,962.5 | 76,297,357.8 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,171,027.0 | 176,000,224.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 62,104,918.0 | 46,198,795.9 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,360,547,300.0 | 946,448,150.1 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,360,547,300.0 | 946,448,150.1 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | 0.0 | 360,923,119.0 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 0.0 | 360,923,119.0 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,853,029,384.8** | **1,859,881,228.5** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,751,466,551.8 | 1,707,716,199.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,497,586,745.0 | 1,620,995,273.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 597,185,948.1 | 658,701,179.6 |
| 210101 | Үндсэн цалин | 401,083,108.6 | 371,737,400.0 |
| 210102 | Нэмэгдэл | 178,481,335.5 | 268,453,022.1 |
| 210104 | Урамшуулал | 17,621,504.0 | 18,510,757.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 71,661,442.6 | 83,399,656.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,440,439.0 | 56,559,496.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,984,050.8 | 6,634,837.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,199,269.7 | 3,352,106.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,579,665.2 | 3,315,863.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,458,017.9 | 13,537,352.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 82,944,382.6 | 100,177,833.8 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,322,152.3 | 28,666,996.8 |
| 210302 | Түлш, халаалт | 57,133,153.1 | 63,049,926.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,489,077.2 | 8,460,911.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 40,044,215.8 | 43,872,025.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,793,600.0 | 6,094,100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,590,404.8 | 30,691,399.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,926,961.0 | 4,671,776.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,990,250.0 | 539,750.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 743,000.0 | 1,875,000.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,180,170.0 | 30,659,800.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.0 | 6,000,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 16,180,170.0 | 24,659,800.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,774,500.0 | 7,450,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,774,500.0 | 7,450,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,939,861.0 | 43,634,720.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,531,027.0 | 40,111,250.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 700,000.0 | 0.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 476,340.0 | 343,350.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 450,364.0 | 769,900.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 572,960.0 | 2,410,220.0 |
| 210807 | Газрын төлбөр | 209,170.0 | 0.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 668,856,225.1 | 653,100,059.5 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 95,533,810.0 | 190,266,319.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 573,322,415.0 | 462,833,740.5 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 253,879,806.8 | 86,720,925.6 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 51,724,473.5 | 25,917,404.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,435,500.0 | 25,917,404.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,122,100.0 | 0.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 27,166,873.5 | 0.0 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 202,155,333.3 | 0.0 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 202,155,333.3 | 0.0 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 0.0 | 28,564,800.9 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.0 | 28,564,800.9 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.0 | 32,238,720.7 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.0 | 32,238,720.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 101,562,833.0 | 152,165,029.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 101,562,833.0 | 152,165,029.0 |
| 220001 | Барилга байгууламж | 0.0 | -1,306,211.0 |
| 221001 | Их засвар | 0.0 | 40,389,000.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | 101,562,833.0 | 113,082,240.0 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 183,499,359.0 | 224,109,754.9 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 120,389,458.7 | 28,993,470.3 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 82,171,955.5 | 22,993,470.3 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 38,217,503.2 | 6,000,000.0 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -120,389,458.7 | -28,993,470.3 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **63,109,900.2** | **195,116,284.6** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,546,031,207.5** | **1,605,867,646.8** |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,546,031,207.5 | 1,605,867,646.8 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 185,483,907.5 | 298,496,377.7 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,000,000.0 | 0.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 95,207,962.5 | 76,297,357.8 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,171,027.0 | 176,000,224.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 62,104,918.0 | 46,198,795.9 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,360,547,300.0 | 1,307,371,269.1 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,360,547,300.0 | 946,448,150.1 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | 0.0 | 360,923,119.0 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,292,304,524.5** | **1,143,952,017.8** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,292,304,524.5 | 1,143,952,017.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,038,252,217.7 | 1,057,024,996.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 597,185,898.1 | 658,701,179.6 |
| 210101 | Үндсэн цалин | 399,723,088.1 | 371,737,400.0 |
| 210102 | Нэмэгдэл | 179,841,305.9 | 268,453,022.1 |
| 210104 | Урамшуулал | 17,621,504.0 | 18,510,757.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 70,358,790.3 | 83,125,766.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,137,736.7 | 56,559,496.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,984,050.8 | 6,634,837.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,199,269.7 | 3,352,106.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,579,665.2 | 3,315,863.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,458,068.0 | 13,263,463.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 84,594,197.4 | 95,534,682.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,322,152.3 | 28,666,996.8 |
| 210302 | Түлш, халаалт | 58,433,153.1 | 54,218,685.3 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,838,892.0 | 12,649,000.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 38,922,851.0 | 30,709,436.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,095,900.0 | 2,661,301.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,649,990.0 | 21,545,360.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,376,961.0 | 4,726,775.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,200,000.0 | 1,300,000.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.0 | 476,000.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 112,411,420.0 | 32,601,800.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,420,000.0 | 6,950,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 109,991,420.0 | 25,651,800.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,441,000.0 | 7,783,500.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,441,000.0 | 7,783,500.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 23,469,861.0 | 39,065,240.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,061,027.0 | 36,800,950.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 700,000.0 | 0.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 476,340.0 | 370,590.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 443,464.0 | 574,000.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 579,860.0 | 1,319,700.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,000,000.0 | 0.0 |
| 210807 | Газрын төлбөр | 209,170.0 | 0.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 103,868,200.0 | 109,503,392.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 103,868,200.0 | 109,503,392.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 254,052,306.8 | 86,927,021.6 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 51,896,973.5 | 26,123,500.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,608,000.0 | 26,123,500.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,122,100.0 | 0.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 27,166,873.5 | 0.0 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 202,155,333.3 | 0.0 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 202,155,333.3 | 0.0 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 0.0 | 28,564,800.9 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.0 | 28,564,800.9 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.0 | 32,238,720.7 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.0 | 32,238,720.7 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 253,726,683.0 | 461,915,629.0 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 253,726,683.0 | 461,915,629.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 253,726,683.0 | 461,915,629.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 253,726,683.0 | 461,915,629.0 |
| 220001 | Барилга байгууламж | 0.0 | 47,683,789.0 |
| 221001 | Их засвар | 0.0 | 26,834,000.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | 253,726,683.0 | 269,982,240.0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.0 | 117,415,600.0 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -253,726,683.0 | -461,915,629.0 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 0.0 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **667,794,348.38** | **200,599,917.64** | **3,327,582,057.00** | **4,195,976,323.02** |
| D01 | **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **667,794,348.38** | **200,599,917.64** | **3,327,582,057.00** | **4,195,976,323.02** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 867,974.98 | 867,974.98 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **667,794,348.38** | **200,599,917.64** | **3,328,450,031.98** | **4,196,844,298.0** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -867,974.98 | 00.00 | -867,974.98 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 195,116,284.58 | 195,116,284.58 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **667,794,348.38** | **199,731,942.66** | **3,523,566,316.56** | **4,391,092,607.6** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,140,751,200.00 | 1,275,132,548.40 | 865,618,651.6 | 59.6% |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,140,751,200.00 | 1,275,132,548.40 | 865,618,651.6 | 59.6% |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,858,570,700.00 | 1,078,536,259.40 | 780,034,440.6 | 58.0% |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 599,787,100.00 | 592,326,969.35 | 7,460,130.6 | 98.8% |
| **Үндсэн цалин** | 374,112,088.70 | 371,737,400.00 | 2,374,688.7 | 99.4% |
| **Нэмэгдэл** | 202,593,311.30 | 202,593,311.35 | 0.0 | 100% |
| **Урамшуулал** | 23,081,700.00 | 17,996,258.00 | 5,085,442.0 | 78.0% |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 74,973,400.00 | 74,973,400.00 | 0.0 | 100% |
| **Тэтгэврийн даатгал** | 50,981,900.00 | 50,981,900.00 | 0.0 | 100% |
| **Тэтгэмжийн даатгал** | 5,974,772.38 | 5,974,772.38 | 0.0 | 100% |
| **ҮОМШӨ-ний даатгал** | 3,022,027.62 | 3,022,027.62 | 0.0 | 100% |
| **Ажилгүйдлийн даатгал** | 2,998,900.00 | 2,998,900.00 | 0.0 | 100% |
| **Эрүүл мэндийн даатгал** | 11,995,800.00 | 11,995,800.00 | 0.0 | 100% |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 89,581,700.00 | 83,160,682.05 | 6,421,018.0 | 92.8% |
| **Гэрэл, цахилгаан** | 29,331,700.00 | 28,666,996.80 | 664,703.2 | 97.7% |
| **Түлш, халаалт** | 60,250,000.00 | 54,218,685.25 | 6,031,314.8 | 90.0% |
| **Цэвэр, бохир ус** | 00.00 | 275,000.00 | -275,000.0 | |
| Хангамж, бараа материалын зардал | 38,900,000.00 | 26,965,676.00 | 11,934,324.0 | 69.3% |
| **Бичиг хэрэг** | 6,300,000.00 | 2,661,301.00 | 3,638,699.0 | 42.2% |
| **Тээвэр, шатахуун** | 25,000,000.00 | 17,891,600.00 | 7,108,400.0 | 71.6% |
| **Шуудан, холбоо, интернэтийн төлбөр** | 5,100,000.00 | 4,636,775.00 | 463,225.0 | 90.9% |
| **Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал** | 1,800,000.00 | 1,300,000.00 | 500,000.0 | 72.2% |
| **Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс** | 700,000.00 | 476,000.00 | 224,000.0 | 68.0% |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 124,449,900.00 | 67,778,800.00 | 56,671,100.0 | 54.5% |
| **Багаж, техник, хэрэгсэл** | 76,249,900.00 | 42,127,000.00 | 34,122,900.0 | 55.2% |
| **Урсгал засвар** | 48,200,000.00 | 25,651,800.00 | 22,548,200.0 | 53.2% |
| Томилолт, зочны зардал | 15,000,000.00 | 7,783,500.00 | 7,216,500.0 | 51.9% |
| **Дотоод албан томилолт** | 15,000,000.00 | 7,783,500.00 | 7,216,500.0 | 51.9% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 150,319,400.00 | 117,043,840.00 | 33,275,560.0 | 77.9% |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж** | 143,800,000.00 | 114,779,550.00 | 29,020,450.0 | 79.8% |
| **Даатгалын үйлчилгээ** | 949,700.00 | 370,590.00 | 579,110.0 | 39.0% |
| **Тээврийн хэрэгслийн татвар** | 1,924,000.00 | 574,000.00 | 1,350,000.0 | 29.8% |
| **Тээврийн хэрэгслийн оношилгоо** | 1,319,700.00 | 1,319,700.00 | 0.0 | 100% |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 765,559,200.00 | 108,503,392.00 | 657,055,808.0 | 14.2% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 765,559,200.00 | 108,503,392.00 | 657,055,808.0 | 14.2% |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 41,625,500.00 | 26,123,500.00 | 15,502,000.0 | 62.8% |
| Бусад урсгал шилжүүлэг | 41,625,500.00 | 26,123,500.00 | 15,502,000.0 | 62.8% |
| **Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал** | 34,125,500.00 | 26,123,500.00 | 8,002,000.0 | 76.6% |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | **240,555,000.00** | **170,472,789.00** | 70,082,211.0 | 70.9% |
| Дотоод эх үүсвэрээр | 240,555,000.00 | 170,472,789.00 | 70,082,211.0 | 70.9% |
| **Барилга байгууламж** | 70,000,000.00 | 47,683,789.00 | 22,316,211.0 | 68.1% |
| **Их засвар** | 45,515,000.00 | 26,834,000.00 | 18,681,000.0 | 59.0% |
| **Бусад хөрөнгө** | 114,055,000.00 | 95,955,000.00 | 18,100,000.0 | 84.1% |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,140,751,200.00 | 1,275,132,548.40 | 865,618,651.6 | 59.6% |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,140,751,200.00 | 1,275,132,548.40 | 865,618,651.6 | 59.6% |
| **Орон нутгийн төсвөөс** | 2,140,751,200.00 | 1,275,132,548.40 | 865,618,651.6 | 59.6% |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | | | 0.0 | |
| **Удирдах ажилтан** | 25.00 | 25.00 | | 100% |
| **Гүйцэтгэх ажилтан** | 06.00 | 06.00 | | 100% |
| **Үйлчлэх ажилтан** | 14.00 | 14.00 | | 100% |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 05.00 | 05.00 | | 100% |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,140,751,200.00 | 1,275,132,548.40 | 865,618,651.6 | 59.6% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **168,613,320.27** | **95,904,336.79** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | **168,613,320.27** | 95,904,336.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 141,446,446.77 | 95,904,336.79 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 58,672,068.21 | 66,374,210.29 |
| 210102 | Нэмэгдэл | 47,957,006.18 | 65,859,710.79 |
| 210104 | Урамшуулал | 10,715,062.03 | 514,499.50 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,967,754.56 | 8,152,366.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,809,226.11 | 5,577,596.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 600,057.13 | 660,065.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 257,565.06 | 330,079.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 249,619.06 | 316,963.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,051,287.20 | 1,267,663.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,379,892.00 | 12,374,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,379,892.00 | 12,374,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,181,390.00 | 3,743,760.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,181,390.00 | 3,653,760.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 0 | 90,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,811,027.00 | 4,260,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,811,027.00 | 4,260,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55754315.00 | 1,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,754,315.00 | 1,000,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0 | 174,027,240.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0 | 174,027,240.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 0 | 174,027,240.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **185,483,907.50** | **298,496,377.72** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 185,483,907.50 | 298,496,377.72 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 95,207,962.50 | 76,297,357.79 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,171,027.00 | 176,000,224.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 62,104,918.00 | 46,198,795.93 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.1. Залруулсан алдаа

Аудитаар нийт 959,655.7 мянган төгрөгийн 7 алдаа[1] илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Төвлөрүүлэх шилжүүлгийг үндсэн данс, нэмэлт дансаар салгаж бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.7-д "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "ангилал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан 117,415.6 мянган төгрөгийн зардлыг дутуу тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.6-д "бүх зардал" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг үндсэн хөрөнгө, бараа материалаар нь салгаж бүртгээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.7-д "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "ангилал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4. Бараа материалын үнэ төлбөргүй гарсан зардлыг бараа материалын тодруулга тайланд салгаж тайлагнаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.7-д "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5. Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 4,515.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.6-д "бүх зардал" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6. Ойн хортонтой тэмцэх 1500 га ажил гүйцэтгэх гэрээний дагуу Мөнх ногоон жодоо ХХК-д өгөх 75,000.0 мянган төгрөгийг 36,591.3 мянган төгрөг гэж 38,408.7 мянган төгрөгийг дутуу бүртгэсэн. Мөн Буян ус ХХК-тай ундны усны худаг гаргах ажилд 54,646.1 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 21,225.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан боловч, бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-д "бүх өр төлбөр" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

7. Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.7-д "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

**5.2. Залруулаагүй алдаа**

Аудитаар нийт 597,062.6 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 142,147.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 454,914.9 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 392,837.1 мянган төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлд тусгаснаас 109,529.9 мянган төгрөгийн өр төлбөрийг холбогдох байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, бараа материалын жилийн эцсийн тооллого хийсэн боловч илтгэх хуудсаар баримтжуулж, дүнг нэгтгээгүй зэрэг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 107,043.7 мянган төгрөгөөр давсан тул **"Хязгаарлалттай"** дүгнэлт өглөө.

**5.2.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй.

**1.2.2 Албан шаардлага**

**Илрүүлэлт 1:** Засаг даргын шийдвэр гараагүй, гэрээ байгуулаагүй байхад золбин нохой устгалын ажилд 2025 оны 9 сард 1,400.0 мянган төгрөг зарцуулсан байна. Нохой устгалын ажлын тайланд өмнөх 4 сард хийж гүйцэтгэсэн ажлын зургийг хавсаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх зарчим", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.3-д "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дараалаар гүйцэтгэнэ", 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэснийг, зөрчсөн ба санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "...зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

**Илрүүлэлт 2:** Цалин хөлстэй холбоотой анхан шатны баримтуудыг нийгмийн даатгал, татварын тайлантай тулган баталгаажуулахад ажилтан болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2,403.2 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын суутгал 1,656.9 мянган төгрөг зөрүүтэй байна. Холбогдох байгууллагуудтай

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тооцоо нийлсэн актаар тулган баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “...авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

**<u>Илрүүлэлт 3:</u>** Нийт 392,837.1 мянган төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлд тусгаснаас 109,529.9 мянган төгрөгийн өр төлбөрийг холбогдох байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэснийг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “...авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

**<u>Илрүүлэлт 4:</u>** Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхгүйгээр Засаг даргын нөөц хөрөнгөөс 11 удаагийн гүйлгээгээр 19,165.6 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 4.1-т заасныг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “...зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

### 1.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**<u>Илрүүлэлт 1:</u>** Сумын төсвийн шилжих үлдэгдэл болон байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хугацаа алдан 5 төсөл арга хэмжээний гэрээг 2025 оны 6 дугаар сарын 30-аас 8 дугаар сарын 25-ны хооронд байгуулан, оны эцэст өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т “Батлагдсан төсөл, арга хэмжээний

худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах", 13.1.2-т "Энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг, зөрчсөн ба санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь</u>:** Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгаж ажиллахыг зөвлөж байна.

**<u>Илрүүлэлт 2:</u>** Бараа материалын жилийн эцсийн тооллого хийсэн боловч илтгэх хуудсаар баримтжуулж, дүнг нэгтгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.1, 2.2-д заасны дагуу байгууллагын хөрөнгийн тооллогыг явуулж тооцоо бодох" гэж заасныг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь</u>:** Холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн тооллогын баримт материалын анхан шатны баримт материалыг бүрэн бүрдүүлж, ажиллахыг зөвлөж байна.

**<u>Илрүүлэлт 3:</u>** Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 186 ширхэг үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн байна. Цаашид ашиглах боломжтой хөрөнгөд дахин үнэлгээ хийж үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", 31 дүгээр зүйлийн 31.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх зарчим", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-тай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь</u>:** Холбогдох стандарт, журамд нийцүүлэн дахин үнэлгээ хийж, бүртгэлийг шинэчилж, зөрчлийг давтан гаргахгүй байхыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөөг, зөвлөмжийн хэрэгжилтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төвлөрүүлэх шилжүүлгийг үндсэн данс, нэмэлт дансаар салгаж бүртгээгүй байна. | 1 | 60,803.5 | | | 1 | 60,803.5 | 1 | 60,803.5 | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг дутуу тусгасан байна. | 1 | 117,415.6 | 1 | 117,415.6 | | | 1 | 117,415.6 | | |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг үндсэн хөрөнгө, бараа материалаар нь салгаж бүртгээгүй. | 1 | 478,123.4 | | | 1 | 478,123.4 | 1 | 478,123.4 | | |
| Бараа материалын үнэ төлбөргүй гарсан зардлыг бараа материалын тодруулга тайланд салгаж тайлагнаагүй. | 1 | 6,000.0 | | | 1 | 6,000.0 | 1 | 6,000.0 | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 4,515.4 | | | 1 | 4,515.4 | 1 | 4,515.4 | | |
| Ойн хортонтой тэмцэх 1500 га ажил гүйцэтгэх гэрээний дагуу Мөнх ногоон жодоо ХХК-д өгөх 75,000.0 мянган төгрөгийг 36,591.3 мянган төгрөг гэж 38,408.7 мянган төгрөгийг дутуу бүртгэсэн. Мөн Буян ус ХХК-тай ундны усны худаг гаргах ажилд 54,646.1 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 21,225.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан боловч, бүртгээгүй байна. | 1 | 59,633.7 | 1 | 59,633.7 | | | 1 | 59,633.7 | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан байна. | 1 | 233,164.1 | | | 1 | 233,164.1 | 1 | 233,164.1 | | |
| Дүн | 7 | 959,655.7 | 2 | 177,049.3 | 5 | 782,606.4 | 7 | 959,655.7 | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалин хөлстэй холбоотой анхан шатны баримтуудыг нийгмийн даатгал, татварын тайлантай тулган баталгаажуулахад ажилтан болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын суутгал зөрүүтэй байна. Холбогдох байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар тулган баталгаажуулаагүй. | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Нийт 392,837.1 мянган төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлд тусгаснаас 109,529.9 мянган төгрөгийн өр төлбөрийг холбогдох байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 109,529.9 | | | 1 | 109,529.9 | | | | | | |
| Засаг даргын шийдвэр гараагүй, гэрээ байгуулаагүй байхад золбин нохой устгалын ажилд 2025 оны 9 сард 1,400,000.0 төгрөг зарцуулсан байна. Нохой устгалын ажлын тайланд өмнөх 4 сард хийж гүйцэтгэсэн ажлын зургийг хавсаргасан байна. | 1 | 1,400.0 | | | 1 | 1,400.0 | | | | | | |
| Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхгүйгээр Засаг даргын | 1 | 19,165.6 | | | 1 | 19,165.6 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| нөөц хөрөнгөөс 11 удаагийн гүйлгээгээр 19,165.6 мянган төгрөгийн зардал гаргасан байна. | | | | | | | | | | | | |
| Сумын төсвийн шилжих үлдэгдэл болон байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хугацаа алдан 5 төсөл арга хэмжээний гэрээг 2025 оны 6 дугаар сарын 30-аас 8 дугаар сарын 25-ны хооронд байгуулан, оны эцэст өр төлбөр үүсгэсэн байна. | 1 | 454,914.9 | | | | | 1 | 454,914.9 | | | | |
| Бараа материалын жилийн эцсийн тооллого хийсэн боловч илтгэх хуудсаар баримтжуулж, дүнг нэгтгээгүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 186 үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн байна. цаашид ашиглах боломжтой хөрөнгөд дахин үнэлгээ хийж үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **7** | **585,010.4** | **-** | **-** | **4** | **130,095.5** | **3** | 454,914.9 | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| - | - | - | | | | | | |
| | | | | | | | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn